ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Зам, тээврийн хөгжлийн яамны 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** СНАГ-2024/320/НА-СТА- ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаанбаатар хот<br>2024 он | Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг<br>Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn<br>Аудитын менежер: С.Нацагдорж<br>Утас: 260512 Цахим хаяг: natsagdorjs@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Б.Эрдэнэзул<br>Утас: 261740 Цахим хаяг: erdenezulb@audit.gov.mn<br>Аудитор: Д.Эрдэнэчимэг<br>Утас: 261740 Цахим хаяг: Erdenechimegda@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024. 02. 23 № 07/336

танай ____________ -ны № ____________ -т

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА С.БАТБОЛД ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу дагуу Зам, тээврийн хөгжлийн яамны 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Зам, тээврийн хөгжлийн яамны 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 154,309.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс давж, дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, Улсын тэмдэгтийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 43 дугаар зүйлийн 43.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль 13 дугаар зүйлийн 13.7, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль 8 дугаар зүйлийн 8.5, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 7 дугаар зүйлийн 7.7 дахь заалтуудтай нийцээгүй иж бүрэн байх, тохиолдсон байх, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны “Зам, тээврийн хөгжлийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг шинэчлэх батлах тухай” 80 дугаар тогтоолоор тус яам 8 газар, 5 хэлтэстэй, орон тооны дээд хязгаарыг 151 байхаар тогтоосон ба Салбарын хяналтын газар, Бодлого, төлөвлөлтийн газарт Судалгаа, стандарт, статистикийн хэлтэс шинээр байгуулагдан нийт 12 орон тоо нэмэгдсэн байна.

**Аудитын гол асуудал**

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус яам нь Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 287 дугаар тогтоолоор Авто тээврийн үндэсний төв ТӨҮГ-ын балансt бүртгэлтэй Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргийн 2 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах, 1,360,414.1 мянган төгрөгийн өртөгтэй, 1,782 м.кв талбайтай, 2 давхар барилгыг балансаас балансt шилжүүлэн авч яамны болон салбарын албан хаагчдын хүүхдийн цэцэрлэг, зам, тээврийн салбарын цахим мэдээлэл, үйлчилгээний төв, албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх зорилготой дасгалын өрөө, архивын баримт хадгалах зориулалтаар ашиглаж байна.

**Бусад асуудлын хэсэг**

Зам, тээврийн хөгжлийн яамнаас 2023 онд агаарын тээврийн либералчлалыг хэрэгжүүлэх, олон улсын зорчигч тээврийн үйлчилгээг сэргээх бодлого баримталж ажилласны үр дүнд олон улсын зорчигч тээвэрлэлт бүх салбарт өссөн үзүүлэлттэй гарсан бөгөөд нийт 2.2 сая зорчигч тээвэрлэж өмнөх оноос 3.2 дахин өссөн байна.

Мөн тус яамнаас 2023 онд орон нутгийн нислэгийг сэргээх, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх бодлогыг баримтлан ажилласан бөгөөд орон нутгийн 3 чиглэлд нислэг үйлддэг байсныг 8 болгон нэмэгдүүлж, нислэгийн тийзийн үнийг 2-2.5 дахин хямдруулсан байна.

Агаарын харилцааны чиглэлээр Катар, Грек, Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард улсуудын төлөөлөлтэй агаарын харилцааны хэлэлцээрт гарын үсэг зурсан бөгөөд Америкийн Нэгдсэн Улстай Open Sky хэлэлцээрт гарын үсэг зурснаар 2 улс хооронд шууд нислэгтэй болох асуудал бүрэн шийдэгдсэн байна.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 13 зорилтын хүрээнд 141 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 85.9 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

Z:\Yawsan_Bichig\2024\0223 SNAG-103.Docx

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **98,791,070.35** | **5,943,869,456.43** |
| **31** | **МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ** | **48,920,069.12** | **203,519,228.63** |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 48,920,069.12 | 203,519,228.63 |
| 3121 | Төгрөг | 48,920,069.12 | 203,519,228.63 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 0.00 | 544,398.21 |
| 31214 | Бусад төсөл нөөцийн харилцах | 48,920,069.12 | 202,974,830.42 |
| 33 | АВЛАГА | **0.00** | **5,650,171,008.57** |
| 33100 | Ажиллагсадтай холбогдсон авлага | 0.00 | 16,500.57 |
| 335 | Бусад авлага | - | 5,650,154,508.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | - | 5,650,154,508.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 49,871,001.23 | 90,179,219.23 |
| 354 | Хангамжийн материал | 49,871,001.23 | 90,179,219.23 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 9,107,660.00 | 12,748,100.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 4,491,093.00 | 4,491,093.00 |
| 35440 | Түлш шатах тослох материал | - | 1,199,780.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 36,272,248.23 | 71,740,246.23 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **3,798,646,886.17** | **4,974,722,368.48** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **3,798,646,886.17** | **4,974,722,368.48** |
| 392 | Биет хөрөнгө | 1,796,446,086.17 | 2,972,521,568.48 |
| 39201 | Барилга, байгууламж | 1,514,439,398.00 | 2,874,853,510.76 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (332,932,549.03) | (557,980,259.09) |
| 39203 | Авто тээврийн хэрэгсэл | 484,100,000.00 | 484,100,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (255,309,777.21) | (319,466,443.77) |
| 39205 | Машин, тоног төхөөрөмж | 429,617,682.77 | 922,047,339.23 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (118,781,179.86) | (538,131,063.52) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 129,844,374.79 | 197,283,119.39 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (54,531,863.29) | (90,184,634.52) |
| 393 | Биет бус хөрөнгө | 2,002,200,800.00 | 2,002,200,800.00 |
| 39301 | Программ хангамж | 39,027,000.00 | 39,027,000.00 |
| 39302 | Хасагдуулаг | (39,027,000.00) | (39,027,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 2,002,200,800.00 | 2,002,200,800.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **3,897,437,956.52** | **10,918,591,824.91** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН** | **1,681,093.39** | **1,571,482.15** |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 1,681,093.39 | 1,571,482.15 |
| 413 | Өглөг | 1,681,093.39 | 1,571,482.15 |
| 41310 | Ажиллагчидтай холбогдсон өглөг | (0.00) | 792,282.15 |
| 4136 | Бусад өглөг | 1,681,093.39 | 779,200.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 1,681,093.39 | 779,200.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН** | **3,895,756,863.13** | **10,917,020,342.76** |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 3,895,756,863.13 | 10,917,020,342.76 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан | 7,873,278,140.11 | 7,873,278,140.11 |
| 51101 | Өмч: -Төрийн өмч | 7,873,278,140.11 | 7,873,278,140.11 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | (4,223,261,802.23) | 2,798,001,677.40 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (4,038,109,830.53) | (4,223,261,802.23) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | (185,151,971.70) | 7,021,263,479.63 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | | 245,740,525.25 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН** | **3,897,437,956.52** | **10,918,591,824.91** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---:|---:|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **13,866,921,670.72** | **28,787,478,003.68** |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 194,508,983.72 | 18,312,462,374.68 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 194,508,983.72 | 18,312,462,374.68 |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 88,679,585.38 | 11,261,613,318.17 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 10,028,650,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 88,679,585.38 | 1,232,963,318.17 |
| 120009 | Бусад орлого | 105,829,398.34 | 7,050,849,056.51 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 13,672,412,687.00 | 10,475,015,629.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 5,418,769,887.00 | 10,475,015,629.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 5,418,769,887.00 | 8,036,021,387.00 |
| 131002 | Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт | - | 2,438,994,242.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 8,253,642,800.00 | - |
| 131103 | ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс | 4,780,000,000.00 | - |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 3,473,642,800.00 | - |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)** | **14,064,328,063.94** | **21,766,214,524.05** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **14,064,328,063.94** | **14,943,251,958.05** |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 13,664,673,475.67 | 14,475,776,174.83 |
| 2101 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 3,642,548,178.14 | 4,528,981,681.76 |
| 210101 | Цалин | 2,338,099,203.55 | 2,887,709,022.52 |
| 210102 | Нэмэгдэл цалин | 659,784,484.04 | 794,038,266.44 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 420,626,500.00 | 523,603,500.00 |
| 210104 | Урамшуулал | 224,037,990.55 | 323,630,892.80 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 458,168,593.11 | 575,009,994.33 |
| 210201 | Тэтгэврийн даатгалын шимтгэл | 314,908,559.30 | 391,716,344.35 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 36,977,525.08 | 47,672,224.11 |
| 210203 | ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | 29,054,499.84 | 36,222,950.14 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 6,984,364.42 | 9,018,770.63 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын хураамж | 70,243,644.47 | 90,379,705.10 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 108,065,093.15 | 183,255,818.23 |
| 210401 | Бичиг хэргийн материал | 32,200,309.00 | 43,160,037.00 |
| 210402 | Тээвэр, шатахууны зардал | 2,804,532.00 | 12,815,460.00 |
| 210403 | Шуудан холбоо интернетийн төлбөр | 40,938,947.15 | 38,318,804.28 |
| 210406 | Бага үнэ түргэн элэгдэл зүйлс | 32,121,305.00 | 88,961,516.95 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 35,499,210.00 | 37,547,560.00 |
| 210601 | Багаж хэрэгсэл | 11,760,100.00 | 10,759,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 23,739,110.00 | 26,788,560.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 79,880,720.00 | 494,886,305.54 |
| 210701 | Гадаад томилолтын зардал | - | 166,761,467.54 |
| 210702 | Дотоод томилолтын зардал | 79,880,720.00 | 328,124,838.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж | 4,127,467,993.12 | 5,811,862,179.56 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 4,069,224,001.00 | 5,697,062,497.39 |
| 210803 | Даатгалын үйлчилгээний төлбөр | 601,890.00 | 9,852,790.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 1,059,060.00 | 589,532.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 253,000.00 | 176,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210806 | Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс | 32,680,102.12 | 78,467,696.17 |
| 210807 | Газрын төлбөр | 1,496,040.00 | 3,713,264.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягтын зардал | 22,153,900.00 | 22,000,400.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,213,043,688.15 | 2,844,232,635.41 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,967,595,805.00 | 2,554,262,059.55 |
| 210902 | Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал | - | 14,146,690.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 245,447,883.15 | 275,823,885.86 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 399,654,588.27 | 467,475,783.22 |
| 2131 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | 12,841,200.00 | 23,175,600.00 |
| 213102 | Засгийн газрын гадаад шилжүүлэг | 12,841,200.00 | 23,175,600.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 359,115,290.00 | 432,684,921.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 51,697,638.00 | 76,853,632.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 172,550,000.00 | 206,550,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 134,867,652.00 | 149,281,289.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 27,698,098.27 | 11,615,262.22 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 27,698,098.27 | 11,615,262.22 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | - | 6,822,962,566.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | - | 6,822,962,566.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | - | 6,822,962,566.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)** | **(197,406,393.22)** | **7,021,263,479.63** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)** | **110,420,555.60** | **-** |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 110,420,555.60 | - |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V)** | **(110,420,555.60)** | **-** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)** | **(185,151,971.70)** | **7,021,263,479.63** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* *\/төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **13,778,242,085.34** | **27,554,514,685.51** |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 105,829,398.34 | 17,079,499,056.51 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 105,829,398.34 | 17,079,499,056.51 |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | - | 10,028,650,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 10,028,650,000.00 |
| 120009 | Бусад орлого | 105,829,398.34 | 7,050,849,056.51 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 13,672,412,687.00 | 10,475,015,629.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 5,418,769,887.00 | 10,475,015,629.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 5,418,769,887.00 | 8,036,021,387.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 8,253,642,800.00 | - |
| 131103 | ЗГНХ, ЗДНХөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс | 4,780,000,000.00 | 2,438,994,242.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 3,473,642,800.00 | - |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)** | **13,806,962,990.00** | **20,358,016,910.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **13,806,962,990.00** | **20,358,016,910.00** |
| 210 | БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 13,407,308,401.73 | 14,240,385,952.78 |
| 2101 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 3,642,548,178.14 | 4,528,516,700.00 |
| 210101 | Үндсэн цалин | 2,341,764,835.92 | 2,887,041,209.42 |
| 210102 | Нэмэгдэл | 658,639,097.01 | 797,756,370.53 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 419,257,331.04 | 526,011,999.11 |
| 210104 | Үр дүнгийн урамшуулал | 222,886,914.17 | 317,707,120.94 |
| 2102 | Ажил олгогчоос нийтийн даатгалд төлөх шимтгэл | 452,963,934.09 | 574,864,157.90 |
| 210201 | Тэтгэврийн даатгалын шимтгэл | 309,703,900.28 | 391,833,878.99 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 36,977,525.08 | 47,408,853.04 |
| 210203 | ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | 29,054,499.84 | 36,222,950.14 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 6,984,364.42 | 9,018,770.63 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын хураамж | 70,243,644.47 | 90,379,705.10 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 99,051,551.38 | 176,949,248.78 |
| 210401 | Бичиг хэрэг | 28,503,650.00 | 48,317,679.95 |
| 210402 | Тээвэр, шатахуун | - | 14,015,240.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 39,015,729.38 | 39,834,934.28 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 31,532,172.00 | 74,781,394.55 |
| 2105 | Нормативд зардал | - | 1,374,500.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | - | 1,374,500.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 41,280,670.00 | 55,744,600.00 |
| 210601 | Багаж техник хэрэгсэл | 5,890,100.00 | 17,087,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 35,390,570.00 | 38,657,100.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 84,613,422.00 | 495,343,853.54 |
| 210701 | Гадаад албан томилолт | - | 166,761,467.54 |
| 210702 | Дотоод албан томилолт | 84,613,422.00 | 328,582,386.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 4,123,310,743.12 | 5,829,500,929.56 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж | 4,069,648,551.00 | 5,710,845,997.39 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 601,890.00 | 9,852,790.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 1,059,060.00 | 589,532.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 253,000.00 | 176,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 29,420,102.12 | 78,467,696.17 |

| | | | |
|---|---|---|---|
| 210807 | Газрын төлбөр | 1,496,040.00 | 3,713,264.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 20,832,100.00 | 25,855,650.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,963,539,903.00 | 2,578,091,963.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,963,539,903.00 | 2,563,945,273.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | - | 14,146,690.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 399,654,588.27 | 6,117,630,957.22 |
| 2131 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | 12,841,200.00 | 23,175,600.00 |
| 213102 | Засгийн газрын гадаад шилжүүлэг | 12,841,200.00 | 23,175,600.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 359,115,290.00 | 432,685,587.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 51,697,638.00 | 76,854,298.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал | 172,550,000.00 | 206,550,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 134,867,652.00 | 149,281,289.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 27,698,098.27 | 11,615,262.22 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 27,698,098.27 | 11,615,262.22 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | - | 5,650,154,508.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 5,650,154,508.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **(28,720,904.66)** | **7,196,497,775.51** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **42,862,200.00** | **7,041,898,616.00** |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 42,862,200.00 | 7,041,898,616.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 42,862,200.00 | 7,041,898,616.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | - | 6,822,962,566.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 42,862,200.00 | 218,936,050.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **(42,862,200.00)** | **(7,041,898,616.00 )** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **(71,583,104.66)** | **154,599,159.51** |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **120,503,173.78** | **48,920,069.12** |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **48,920,069.12** | **203,519,228.63** |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /төгрөгөөр/*

| ҮЗҮҮЛЭЛТ | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| 2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 7,873,278,140.11 | 245,740,525.25 | (4,038,109,830.53) | 4,080,908,834.83 |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 7,873,278,140.11 | 245,740,525.25 | (4,038,109,830.53) | 4,080,908,834.83 |
| Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/ | - | - | (185,151,971.70) | (185,151,971.70) |
| 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 7,873,278,140.11 | 245,740,525.25 | (4,223,261,802.23) | 3,895,756,863.13 |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 7,873,278,140.11 | 245,740,525.25 | (4,223,261,802.23) | 3,895,756,863.13 |
| Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/ | - | - | 7,021,263,479.63 | 7,021,263,479.63 |
| 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 7,873,278,140.11 | 245,740,525.25 | 2,798,001,677.40 | 10,917,020,342.76 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Код | ҮЗҮҮЛЭЛТ | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ | ЗӨРҮҮ | ХУВЬ |
|---|---|---|---|---|---|
| **2** | **I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **8,036,399,300.00** | **8,024,406,124.78** | **11,993,175.22** | **99.8** |
| 21 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 8,036,399,300.00 | 8,024,406,124.78 | 11,993,175.22 | 99.8 |
| 210 | Бараа, үйлчилгээний зардал | 7,580,123,200.00 | 7,568,544,937.78 | 11,578,262.22 | 99.8 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 4,528,516,700.00 | 4,528,516,700.00 | (0.00) | 100.0 |
| 210101 | Үндсэн цалин | 2,634,704,800.00 | 2,887,041,209.42 | (252,336,409.42) | 109.5 |
| 210102 | Нэмэгдэл | 1,005,780,100.00 | 797,756,370.53 | 208,023,729.47 | 79.3 |
| 210103 | Унаа, болон бусад нөхөн олговор | 606,890,000.00 | 526,011,999.11 | 80,878,000.89 | 86.6 |
| 210104 | Урамшуулал | 281,141,800.00 | 317,707,120.94 | (36,565,320.94) | 113.0 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 576,314,500.00 | 574,864,157.90 | 1,450,342.10 | 99.7 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 385,834,400.00 | 391,833,878.99 | (5,999,478.99) | 101.5 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 49,065,200.00 | 47,408,853.04 | 1,656,346.96 | 96.6 |
| 210203 | ҮОМШӨ ний даатгал | 39,252,100.00 | 36,222,950.14 | 3,029,149.86 | 92.2 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 9,813,000.00 | 9,018,770.63 | 794,229.37 | 91.9 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 92,349,800.00 | 90,379,705.10 | 1,970,094.90 | 97.8 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 187,538,800.00 | 187,538,798.78 | 1.22 | 100.0 |
| 210401 | Бичиг хэрэг | 47,932,500.00 | 48,317,679.95 | (385,179.95) | 100.8 |
| 210402 | Тээвэр (шатахуун) | 14,678,000.00 | 14,015,240.00 | 662,760.00 | 95.4 |
| 210403 | Шуудан холбоо, интернэтийн төлбөр | 39,874,600.00 | 39,834,934.28 | 39,665.72 | 99.9 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс | 85,053,700.00 | 85,370,944.55 | (317,244.55) | 100.3 |
| 2105 | Нормативд зардал | 1,374,500.00 | 1,374,500.00 | - | 100.0 |
| 210503 | Нормын хувцас зөөлөн эдлэл | 1,374,500.00 | 1,374,500.00 | - | 100.0 |
| 2106 | Эд хогшил худалдан авах | 258,591,100.00 | 258,591,100.00 | - | 100.0 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 219,934,000.00 | 219,934,000.00 | - | 100.0 |
| 210604 | Урсгал засвар | 38,657,100.00 | 38,657,100.00 | - | 100.0 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 495,942,000.00 | 495,343,853.54 | 598,146.46 | 99.8 |
| 210701 | Гадаад албан томилолт | 167,340,000.00 | 166,761,467.54 | 578,532.46 | 99.6 |
| 210702 | Дотоод албан томилолт | 328,602,000.00 | 328,582,386.00 | 19,614.00 | 99.9 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | 1,466,035,200.00 | 1,456,505,437.56 | 9,529,762.44 | 99.3 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,341,119,300.00 | 1,337,850,505.39 | 3,268,794.61 | 99.7 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал | 3,967,800.00 | - | 3,967,800.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 9,877,500.00 | 9,852,790.00 | 24,710.00 | 99.7 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 1,313,500.00 | 589,532.00 | 723,968.00 | 44.8 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 249,000.00 | 176,000.00 | 73,000.00 | 70.6 |
| 210806 | Мэдээллийн технологийн зардал | 78,796,800.00 | 78,467,696.17 | 329,103.83 | 99.5 |
| 210807 | Газрын төлбөр | 4,205,300.00 | 3,713,264.00 | 492,036.00 | 88.3 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 26,506,000.00 | 25,855,650.00 | 650,350.00 | 97.5 |
| 2201 | Бараа үйлчилгээний бусад зардал | 65,810,400.00 | 65,810,390.00 | 10.00 | 100.0 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 51,663,700.00 | 51,663,700.00 | - | 100.0 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 14,146,700.00 | 14,146,690.00 | 10.00 | 100.0 |
| | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 456,276,100.00 | 455,861,187.00 | 414,913.00 | 99.9 |
| 2131 | Засгийн газар хоорондын шилжүүлэг | 23,175,600.00 | 23,175,600.00 | - | 100.0 |
| 213102 | Засгийн газрын гадаад шилжүүлэг | 23,175,600.00 | 23,175,600.00 | - | 100.0 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 433,100,500.00 | 432,685,587.00 | 414,913.00 | 99.9 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 77,232,200.00 | 76,854,298.00 | 377,902.00 | 99.5 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, дэмжлэг | 206,587,000.00 | 206,550,000.00 | 37,000.00 | 99.9 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 149,281,300.00 | 149,281,289.00 | 11.00 | 100.0 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 8,036,399,300.00 | 8,024,406,124.78 | 11,993,175.22 | 99.8 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 8,036,399,300.00 | 8,024,406,124.78 | 11,993,175.22 | 99.8 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 8,036,399,300.00 | 8,024,406,124.78 | 11,993,175.22 | 99.8 |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | - | - | - | - |
| 62 | АЖИЛЛАГСДЫН ТОО | 151 | 142 | - | 94.0 |
| 620001 | Удирдах ажилтан | 18 | 16 | - | 88.8 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 128 | 121 | - | 94.5 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 5 | 5 | - | 100.0 |

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| КОД | ҮЗҮҮЛЭЛТ | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ |
|---|---|---|---|
| **2** | **I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **-** | **19,290,606,808.00** |
| 21 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | - | 19,290,606,808.00 |
| 210 | Бараа, үйлчилгээний зардал | - | 13,640,452,300.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | - | 4,378,495,492.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | - | 4,378,495,492.00 |
| 2201 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 9,261,956,808.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 9,261,956,808.00 |
| 213 | Урсгал шилжүүлэг | - | 5,650,154,508.00 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | - | 5,650,154,508.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 5,650,154,508.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **-** | **19,290,606,808.00** |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | - | 16,851,612,566.00 |
| 1200041 | Үндсан үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 16,851,612,566.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | - | 2,438,994,242.00 |
| 131103 | ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс зохих байгууллагын шийдвэрийн дагуу тухай төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 2,438,994,242.00 |

## АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 13,011,449.0 мянган төгрөгийн 4 алдаа илэрснээс аудитын явцад 12,857,140.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 154,309.0 мянган төгрөгийн алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Аудитаар нийт 154,309.0 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 19,132.0 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, 135,177.0 мянган төгрөгийн 4 албан шаардлага хүргүүлж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өглөө.

Аудитаар илэрсэн 154,309.0 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон 141,747.5 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс давсан байгаа тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Өмчийн өөрчлөлтийн тайланд өмнөх оны тайлант үеийн үр дүнг буруу тусган илэрхийлсэн | 1 | 185,152.0 | | | 1 | 185,152.0 | 1 | 185,152.0 | | | | |
| МГТ, нэмэлт санхүүжилтийн тайланд орлого, зарлагын мэдээллийг тусгахгүй орхигдуулсан; | 1 | 6,822,962.6 | | | 1 | 6,822,962.6 | 1 | 6,822,962.6 | | | | |
| Үр дүнгийн тайланд өмнөх оны гүйцэтгэлийг буруу тусган илэрхийлсэн; | 1 | 198,870.9 | | | 1 | 198,870.9 | 1 | 198,870.9 | | | | |
| Сангийн яамтай санхүүжилтийн тооцоо нийлээгүй, татаас санхүүжилтийн авлагыг буруу тусган илэрхийлсэн | 1 | 5,650,154.5 | | | 1 | 5,650,154.5 | 1 | 5,650,154.5 | | | | |
| **Нийт алдаа** | **4** | **12,857,140.0** | | | **4** | **12,857,140.0** | **4** | **12,857,140.0** | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Үйл ажиллагааны төлөвлөгөөнд өөрчлөлт оруулж зарим төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйгээс үлдсэн 625,000.0 мянган төгрөгийн зарцуулагдаагүй үлдэгдлийг төсөвт төвлөрүүлэлгүй, хэвлэл, мэдээллийн зардал, судалгааны ажлыг байгууллага, хувь хүмүүсээр гүйцэтгүүлэн гэрээт ажлын төлбөрт зарцуулсан байна. | 1 | 0.0 | | | | | 1 | 0 |
| Урсгал зардлаас 135,177.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэхдээ худалдан авалтад гүйцэтгэгчийг харьцуулалтын болон нээлттэй тендер сонгон шалгуулах журмаар сонгон шалгаруулаагүй, шууд гэрээ байгуулан худалдан авалт хийсэн байна. | 1 | 135,177.0 | | | 1 | 135,177.0 | | |
| ЗГ-ын 2023 оны 80 дугаар тогтоолын дагуу зохион байгуулалтын бүтэц, орон тоог шинэчлэн баталж, Судалгаа, стандарт, статистикийн хэлтсийг шинээр байгуулан чиг үүргийг баталсан байна. Тухайн хэлтсийн чиг үүрэгт хамаарах ажлыг 9 хувь хүн, хуулийн этгээдээр гүйцэтгүүлж 163,300.0 мянган төгрөгийн гэрээ байгуулан салбарын бодлогыг салбарын бус судалгааны багаар гүйцэтгүүлэн үр дүнгүй зардал гаргасан байна. /Гүйцэтгэл хүлээн аваагүй судалгааны 5 ажилд 93,400.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна/ | 1 | 0.0 | | | | | 1 | 0 |
| МУЗГ-ын 2023 оны 490 дүгээр "Улсын чанартай авто замд хийгдсэн өвлийн арчлалтын онцгой ажилд зарцуулах хөрөнгийн жагсаалт батлах тухай "тогтоолын дагуу Зам тээврийн хөгжлийн төвд 59,886.7 мянган төгрөгийн техник хяналтын зардал олгосон боловч хойд бүс нутагт хамаарах аймгуудад техник хяналт ажлын талбарт хэрэгжүүлээгүй байхад 4,259.1 мянган төгрөг олгосон байна. | 1 | 4,259.1 | 1 | 4,259.1 | | | | |
| Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын гэрчилгээг цахимжуулах 10.0 тэрбум төгрөгийн арга хэмжээг 2023 онд бүрэн дуусгах байсан ч ажлын хэсгийн уялдаа холбоо муу байгаагаас 43.5 хувийн хэрэгжилттэй байна. МУЗГ-ын хуралдааны 2022 оны 47 дугаар тэмдэглэл, МУ-ын замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн 2022 оны 04 дүгээр тогтоолоор өгөгдсөн чиглэлийн дагуу ЗТХС, МУС, Нийслэлийн Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах үндэсний хорооны даргын хамтарсан 2022 оны А/287, А/02 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулсан бөгөөд, эх үүсвэрийг Жолоочийн даатгалын сангаас шийдвэрлэж, тус арга хэмжээг Улаанбаатар хотод 2022 онд, орон нутагт 2023 онд бүрэн хэрэгжүүлж дуусгахаар төлөвлөсөн байна. | 1 | 0.0 | | | 1 | 0.00 | | |
| Тус яам нь Авто замын тусгай зөвшөөрөл, Төмөр замын тусгай зөвшөөрөл, Авто тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг хийх, улсын дугаарын үйлдвэр эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгож орон нутгийн төсөвт /Сүхбаатар дүүргийн ХХБ-ны 495089309 дансанд/ тэмдэгтийн хураамжийн орлого 578,700.0 мянган | 1 | 0.0 | | | 1 | 0.00 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| төгрөгийг төвлөрүүлсэн боловч бүртгэлээр тавих хяналт хангалтгүй, орлогын бүрдүүлэлтийн тооцоог нийлж, актаар баталгаажуулаагүй байна. | | | | | | | | |
| Тус яамны салбарын хяналтын газрын эрх бүхий албан тушаалтнууд нь Зөрчлийн тухай хуулийн дагуу оногдуулсан торгуулийн 108,550.0 мянган төгрөгийн орлогыг Төрийн сангийн дансанд төвлөрүүлсэн боловч Сангийн яамтай тооцоо нийлж баталгаажуулаагүй, шийтгэлийн хуудсаар оногдуулсан 2,700.0 мянган төгрөгийн торгуулийн орлогыг төсөвт төвлөрүүлээгүй, бүртгэлээр тавих хяналт хангалтгүй байна. | 1 | 2,700.0 | 1 | 2,700.0 | | | | |
| Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 225 төрлийн 729,031,231.0 төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байгааг ашиглах болон дахин үнэлүүлэн, бодит үнэ цэнээр бүртгэх асуудлыг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна. | 1 | - | | | | - | 1 | |
| Хэрэгжих боломжгүй болсон 5 нэр төрлийн барилгын ажлын зураг, төсвийн зардлаас урьдчилан 12,172.9 мянган төгрөгийн техник, хяналтын зардлыг суутган авсан ч үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлээгүй байна. | 1 | 12,172.9 | 1 | 12,172.9 | | | | |
| Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын шийдвэрийн дагуу Чайна гео инженеринг корпорац ХХК-аас авах Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн 50 км хатуу хучилттай авто замын хохирол барагдуулах ажлын төлбөр 6,822,962.6 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлснийг улсын төсөвт төвлөрүүлэлгүй, Налайх АЗЗА ТӨХК, Ховд АЗЗА ТӨХК, Харгуй АЗЗА ТӨХК, Архангай АЗЗА ТӨХК-иудтай шууд гэрээ байгуулан зам засварын ажилд зарцуулахаар Улсын автозамын санд шилжүүлсэн байна. | 1 | - | | | 1 | - | | |
| **Нийт дүн** | **10** | **154,309.0** | **3** | **19,132.0** | **4** | **135,177.0** | **3** | **0.0** |

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 2 зөрчил илэрснээс 2 зөвлөмж өгсөн.

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Тайлант онд нийт 166 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулахаас 147 мэдээллийг хугацаанд нь, 19 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. | 1 | - | | | | | 1 | - |
| | 1 | - | | | | | | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Төмөр замын тусгай зөвшөөрөл шинээр авсан, хугацаа сунгасан нийт 61 зөвшөөрлөөс 54 зөвшөөрөлд 5,000.0 мянган төгрөг, 7 зөвшөөрөлд 2,000.0 мянган төгрөгийн тэмдэгтийн хураамж харилцан адилгүй авч байгаа нь хураамжийн хэмжээг нарийвчлан тогтоогоогүй, хяналт хангалтгүй байгааг харуулж байна. | 1 | | | | | | 1 | - |
| Дүн | 1 | - | | | | - | 1 | - |
| **Нийт дүн** | **2** | **-** | | | | **-** | **2** | **-** |